



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗАСГИЙН ГАЗРЫН ШУГАМААР ХАНДИВЛАГЧ ОРОН, ОЛОН УЛСЫН
БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН АШИГЛАЛТ, ҮР ДҮН**

ᠲᠦ᠋ᠷᠢᠶᠢᠨᠠᠭᠤᠳᠢᠲᠤᠨᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠠᠭ᠎ᠠ

Улаанбаатар хот 2022 он



ᠠᠨᠠᠨᠢ
ᠰᠤᠮᠤᠨ
ᠠᠸᠢᠨ

ЗАСГИЙН ГАЗРЫН ШУГАМААР ХАНДИВЛАГЧ ОРОН, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН АШИГЛАЛТ, ҮР ДҮН

Аудит зорилт:



- Засгийн газрын шугамаар олон улсын байгууллагаас авсан зээлийг үр дүнтэй ашигласан эсэх;
- Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн ашиглалт үр дүнтэй байгаа эсэх;

Аудитын хамарсан хүрээ:



Аудитыг 2018-2020 оны байдлаарх шинээр олгосон болон үргэлжилж буй гадаад зээл, тусламжийн ашиглалт, дамжуулан зээлд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын зээлтэй холбогдох үйл ажиллагааны мэдээлэл, тайлан, бусад нотлох баримт, материал үндэслэн гүйцэтгэсэн болно.



ᠤᠨᠳᠡᠰᠢᠨ
ᠠᠭᠤᠳᠢᠲᠤᠨ
ᠭᠠᠰᠠᠷ

● Ерөнхий мэдээлэл

Засгийн газрын гадаад зээлийн өсөлт

2018 онд өмнөх оноос **22.3** хувиар,

2019 онд **14.3** хувиар,


2020 онд **28.9** хувиар тус тус өссөн байна.

Нийт өсөлтийг **100** хувь гэж авч үзвэл ханшийн өөрчлөлтөөр

2018 онд **40.8** хувиар,

2019 онд **25.0** хувиар,

2020 онд **27.7** хувиар тус тус нэмэгдсэн байна.





ᠤᠨᠳᠡᠰᠨᠢᠢ
ᠠᠭᠤᠳᠢᠲᠤᠨ
ᠭᠠᠰᠠᠷ

● Ерөнхий мэдээлэл




Төрөл	Нэгж	2018 он	2019 он	2020 он	Нийт	Хувь
Төсөл, арга хэмжээний зээл	тэрбум төгрөг	1,007.2	1,230.5	1,390.3	3,627.9	55.9
	сая ам.доллар	400.7	459.7	493.0	1,353.4	
Хөтөлбөрийн зээл /төсвийн дэмжлэг	тэрбум төгрөг	474.9	408.1	1,978.1	2,861.2	44.1
	сая ам.доллар	190.0	150.5	702.0	1,042.5	
Нийт	тэрбум төгрөг	1,482.1	1,638.6	3,368.4	6,489.1	100.0
	сая ам.доллар	590.7	610.2	1,195.0	2,395.9	



ᠤᠨᠳᠡᠰᠢᠨ
ᠠᠭᠤᠳᠢᠲᠤᠨ
ᠭᠠᠰᠠᠷ

● **Ерөнхий мэдээлэл**

Санхүүжүүлэгч байгууллага, хувиар /2018-2020/:





■ АХБ ■ БНХАУ ■ Япон улс ■ ДБ ■ Бусад


Зээл авсан салбар, хувиар:






 Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагын зээлээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх эрх зүйн зохицуулалт бүрэн бүрдээгүй байна

 Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг батлан хэрэгжүүлсэн нь төсөл, арга хэмжээг удаашруулж, төсөл, арга хэмжээний нийгэм эдийн засагт бий болгох ач холбогдолыг бууруулж байна

 Засгийн газрын гадаад зээлийн бодлого тодорхойлогдоогүйгээс гадаад зээлээр санхүүжүүлэх Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, зорилт хэрэгжигдэхгүй байх эрсдэлийг нэмэгдүүлж байна



Урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ хандивлагч орон, олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагын бодлоготой өөрийн орны бодлогыг уялдуулан идэвхтэй хамтран ажиллах талаар стратеги түншлэлийн хэлэлцээрийг сайжруулах, үйлдвэрлэлийн салбарын зээлийн ашиглалтыг нэмэгдүүлж, үйлдвэрийн орлого, ашгаар эдийн засагт дэмжлэг болох зэргээр **зээлийн үр ашгийг нэмэгдүүлэх** боломжтой байна.



ᠤᠨᠳᠡᠰᠢᠨ
ᠠᠭᠤᠳᠢᠲᠤᠨ
ᠭᠠᠰᠠᠷ

● Дотоодод дамжуулсан зээлийн 47.0 хувь нь эргэн төлөгдөөгүй байна



Эргэн төлөлт хийдэггүй дотоодод дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдэл жил бүр нэмэгдэж, 2020 оны жилийн эцэст нийт **73** зээлийн **1,402.0 тэрбум төгрөгт** хүрсэн байна.




Дотоодод төгрөгөөр олгосон нийт **577.0** тэрбум төгрөгийн **118** дамжуулан зээлийн хүүгийн төлбөрт **2020** оны жилийн эцсийн байдлаар **50.8** тэрбум төгрөгийн ханшийн алдагдал хүлээсэн байна.



Эрчим хүчний салбарт олгосон **204.5** тэрбум төгрөгийн **27** зээлийг **“Тогтоол хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”** Сангийн сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2011 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хамтарсан 276/300 дугаар тушаалаар төгрөгт тооцож, шилжүүлсэн байна.

Эргэн төлөлт хийдэггүй дамжуулан зээлийн үлдэгдэл /тэрбум төгрөг/





ᠮᠤᠩᠭᠡᠯᠤ
ᠰᠤᠮᠤᠨ
ᠠᠸᠢᠭᠤᠯᠠᠲᠤ



Засгийн газрын гадаад зээлийн 44.1 хувийг төсвийн алдагдлыг нөхөхөд зарцуулагдаж байна. Төсвийг алдагдалгүй батлах нь Засгийн газрын гадаад зээлийг бууруулах том хүчин зүйл болохоор байна.

Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д заасныг үндэслэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар


2018 онд 474.8 тэрбум,

2019 онд 408.1 тэрбум,

2020 онд 1,978.0 тэрбум,

Нийт **2,860.9** тэрбум төгрөгийн гадаад зээлийг хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцэл ба төсвийн алдагдлыг нөхөх зээлийн ашиглалт /тэрбум төгрөг/



Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зээлийн хөдөлгөөн /тэрбум төгрөг/

Он	Эхний үлдэгдэл	Ашиглалт	Эргэн төлөлт	Ханшийн өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл
2018	1,919.2	474.8	3.5	227.2	2,617.7
2019	2,617.7	408.1	35.7	98.0	3,088.1
2020	3,088.1	1,978.0	67.6	225.0	5,223.5



Ундэсний
Аудитын
Газар

● **Засгийн газрын гадаад зээлийн ханшийн эрсдэл**

Гадаад зээлийн багцыг валютын бүтцээр нь харвал

39.5 хувь нь **ам.доллар**,

27.1 хувь нь **зээлжих тусгай эрх**,

24.7 хувь нь **иен**,

5.8 хувь нь **евро**,

2.9 хувь нь **бусад валютаас** бүрдсэн байна.

Гадаад зээлийн үлдэгдэл нэмэгдэх эрсдэлтэй.

Бодит ханшийн алдагдал хүлээх эрсдэлтэй байна.

Ханш **5** хувь сулрахад **2021-2024 онд 824.4-954.7** тэрбум төгрөгөөр

Ханш **10** хувь сулрахад **2021-2024 онд 1,649.1-2,195.4** тэрбум төгрөгөөр

Ханш **15** хувь сулрахад **2021-2024 онд 2,470.8-3,762.8** тэрбум төгрөгөөр

Төгрөгийн ханш **10** хувь сулрахад өрийн үйлчилгээний зардал

Төгрөгийн ханш **5** хувь сулрахад өрийн үйлчилгээний зардал

2021-2025 онд 618.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэх


2021-2025 онд 309.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэх



ᠤᠨᠳᠡᠰᠢᠨ
ᠠᠭᠤᠳᠢᠲᠤᠨ
ᠭᠠᠰᠠᠷ


Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн бүртгэл хангалтгүй байна

Санхүүжүүлэгч байгууллага, хувиар



■ АХБ ■ БНХАУ ■ Япон ■ АНУ ■ Бусад

Тусламжийн ашиглалт, салбараар /хувь/



■ Эрүүл мэнд ■ Боловсрол ■ Хотын хөгжилд ■ Ус хангамж

Бүртгэл хангалтгүй
29 төсөл, арга хэмжээ

61.8% Ангилал тодорхойгүй

56.2% Шилэн дансны хөтлөлт хангалтгүй

2018 онд **26** төсөлд **43.8** сая ам.доллар
2019 онд **23** төсөлд **38.1** сая ам.доллар
2020 онд **30** төсөлд **156.1** сая ам.доллар



Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилт, үр дүн тайлангийн **зөвлөмжүүд**

Монгол Улсын Их Хурлын анхааралд толилуулах нь:

- Өрийн удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т заасан “Засгийн газрын гадаад зээлийн талаар төрөөс баримтлах бодлого”-ыг боловсруулахад Засгийн газарт дэмжлэг үзүүлэх;
- Гадаад зээлийн хөрөнгийг хөгжлийн бодлого, зорилттой уялдуулж, эдийн засаг, нийгмийн үр ашигтай төсөлд зарцуулж, хуулийн шаардлага хангахгүй, эрсдэлийн үнэлгээ хийгээгүй төсөл, арга хэмжээнд төсөв батлахгүй байхад анхаарах;



Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монголбанкнд:

- Өрийн удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 -т заасан Монголбанкнаас хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу Засгийн газрын зээллэгийн хэмжээ мөнгөний болон валютын зах зээлд нөлөөлөх эсэхэд дүгнэлт гарган санал, зөвлөмж хүргүүлэн ажиллах;





Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилт, үр дүн тайлангийн **зөвлөмжүүд**



Засгийн газарт:

- Өрийн удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т заасан “Засгийн газрын гадаад зээлийн талаар төрөөс баримтлах бодлого”-г боловсруулах;
- Төгрөгийн ханш сулрах нөхцөлийг бууруулах үр дүнтэй, иж бүрэн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх;
- Гадаад зээлийн хөрөнгөөр дотоодод дамжуулан зээлдүүлсэн эргэн төлөлт хийгдээгүй 73 зээлийг барагдуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах;
- Гадаад зээлийн хөрөнгийг хөгжлийн бодлого, түүний зорилттой уялдуулж, эдийн засаг, нийгмийн үр ашигтай төсөлд зарцуулж, үр өгөөжийг нэмэгдүүлэх, хуулийн шаардлага хангахгүй, эрсдэлийн үнэлгээ хийгээгүй төсөл, арга хэмжээнд төсөв хуваарилахгүй байх;
- Засгийн газрын гадаад тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг тусламжийн төрөл тус бүрээр бүрэн бүртгэх, хэрэгжилт, үр дүнд тавих хяналтыг сайжруулах;
- Төсөл, арга хэмжээг гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх нэгдсэн удирдлагын тогтолцоог бүрдүүлж, төслийн хэрэгжилт, үр дүнд тавих хяналтыг сайжруулах;



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ᠲᠦ᠋ᠷᠢᠶᠢᠨ
ᠠᠤᠳᠢᠲᠤᠨ
ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠠᠭ᠎ᠠ

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА